

БАТЛАВ.
АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА *[Signature]* Д.СОДНОМ

2019 оны 03 дугаар сарын 15

СҮМБЭР СУМЫН 2-Р БАГ, 640 ХҮҮХДИЙН СУУДАЛТАЙ 2 ДУГААР СУРГУУЛИЙН БАРИЛГЫН АЖЛЫН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Говьсүмбэр аймгийн “Сүмбэр сумын 2-р баг 640 хүүхдийн суудалтай сургуулийн барилгын ажил”-ыг гүйцэтгэхдээ батлагдсан зураг төсөл болон холбогдох стандарт, норм дүрмийн дагуу хийх ба дараах шаардлагуудыг бүрэн хангасан байна. Тус барилгын даацын үндсэн бүтээц нь цутгамал төмөр бетон каркас. Барилга нь 4 блокоос бүрдэнэ. А блок нь тэнхлэгээрээ 24*18м, Б, В блок нь 30*12.5 м, Г блок нь 30*21м байна.

1. Ажилд тавигдах ерөнхий шаардлага:

Барилгын тухай хуулийн 40 дүгээр зүйлд заасан чиг үүргүүдийг хэрэгжүүлж ажилллах бөгөөд батлагдсан зураг төсвийн дагуу ажлыг барилгын норм ба дүрэм /БНБД/ стандартыг баримтлан технологийн дагуу чанартай гүйцэтгэнэ.

- Барилгын үйлдвэрлэлд дагаж мөрдөх хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны норм дүрэм, стандартыг чанд мөрдөн ажиллаж, түүнд шаардагдах хөрөнгийг хуулийн дагуу төлөвлөж зарцуулах
- Гүйцэтгэгч нь зохиогч болон захиалагч, захиалагчийн хяналтын төлөөлөлтэй нягт уялдан ажиллах шаардлагатай.
- Ажлыг үе шат бүрт захиалагчийн хяналтын инженерт үзүүлж, фото зургаар баталгаажуулж, акт үйлдсэний дараа дараагийн ажлыг үргэлжлүүлэн хийх зөвшөөрлийг авч ажиллана.
- Ажилд хэрэглэгдэх материалуудыг барилгын талбай дээр их хэмжээгээр татахаасаа өмнө дээжийг захиалагчид үзүүлж, зөвшилцөх зарчим баримталж ажиллана. Захиалагчтай зөвшилцөөгүй, буруу буюу чанаргүй материал авчирч, ажилд ашиглах тохиолдолд түүнээс үүдэн гарах алдагдлаа гүйцэтгэгч хариуцна.
- Зайлшгүй шаардлагаар барилгын хийцлэл, материалыг өөрчлөх тохиолдолд захиалагчид албан тоотоор хандаж, зохиогч захиалагчаас бичгээр зөвшөөрлийг авч өөрчлөлтийг хийнэ.
- Ажлыг гүйцэтгэх үед дулаан болон холбоо, цахилгааны шугамын утас, газар доорх шугам хоолой, холбоо, цахилгааны утсыг гэмтээсэн тохиолдолд гүйцэтгэгч өөрийн хөрөнгөөр түргэн шуурхай засварлан хангагч байгууллагад хүлээлгэн өгнө.
- Оршин суугчдын аюулгүй байдлыг бүрэн хангаж, ажлын байр, зам гарц, талбайг хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны дүрэмд заасны дагуу бэлтгэж, үйлдвэрлэлийг аюулгүй гүйцэтгэх нөхцлийг бүрэн хангах, хашаа хамгаалалтыг хийж, оршин суугчдын зорчих хэсгийг гаргаж анхааруулах тэмдэг, тэмдэглэгээг хийх. Ажилтнуудыг хамгаалах хэрэгслэлээр бүрэн хангана.
- Орон нутгаас барилгын ажилд хэрэглэгдэх түгээмэл тархацтай ашигт малтмал болон бусад барилгын материалыг авч ашигласан тохиолдолд зохих төлбөр хураамжийг төлөх

Handwritten signature and date: 2015.03.04

- Барилгын ажлын явцад гарсан хог хаягдлыг “Тохижилт Сүмбэр” ОНӨҮГ-аар зөөвөрлүүлэн, төвлөрсөн хогийн цэгт хаяна. Ажил дууссаны дараа талбайг цэвэрлэж хүлээлгэн өгнө.
- Ажлын графикт чанарын хяналтын хугацааг тооцож ирүүлэх бөгөөд хугацааг мөрдөж ажиллана.
- Ажлыг гэрээ байгуулснаас хойш 21 хоногт эхлүүлээгүй тохиолдолд гэрээ цуцлах үндэслэл болно.
- Ажилд тушаалаар томилогдсон мэргэжлийн талбайн инженерийг тогтмол ажиллуулах, мэргэжил шаардсан ажилд мэргэжлийн үнэмлэхтэй ажилчдыг ажиллуулах.
- Үнийн санал ирүүлэхдээ төсвийг ЗТБХБСайдын 2012 оны 181 дүгээр тушаал, Барилгын төсөв зохиох заавар, БНБД81-95-12-г мөрдлөг болгох бөгөөд шууд, нэмэгдэл, ашиг, зохиогчийн болон захиалагчийн хяналтын зардал, нормчлолын сан, НӨАТ, магадлашгүй ажил зэргийг тооцож ирүүлнэ.
- Автотээврийн зардлыг ЗТАЖЯ-ны сайдын 2008 оны 09 дүгээр сарын 08-ны өдрийн 136 тоот тушаалаар батлагдсан жишиг тарифаар тооцно. ЗТБХБ-ын сайдын 2012 оны 18 дугаар тушаалаар машин механизмын зардлыг БД81-112-11 /Барилгын машин ашиглалтын нэг машин-цагийн жишиг үнэ/-ийн дагуу тооцож ирүүлнэ.
- Гүйцэтгэгч нь ажил хийгдэх талбайн гадна иргэд, олон нийтэд зориулсан тухайн бүтээн байгуулалтыг танилцуулах 2*4-оос багагүй хэмжээний самбарыг байршуулна.
- Ажил дууссаны дараа гүйцэтгэлийн зургийг гаргаж, захиалагч болон хяналтын байгууллагад ирүүлнэ.
- Барилга угсралтын ажлыг дулааны улиралд гүйцэтгэнэ.
- Техникийн тодорхойлолтод заагдсан шаардлагыг биелүүлээгүй нөхцөлд захиалагчийн төлөөлөгч, Мэргэжлийн хяналтын улсын байцаагч эрхийнхээ дагуу ажлыг тодорхой хугацаагаар зогсоох, “Зөрчлийн тухай” хуулийн дагуу захиргааны арга хэмжээ авах эрхтэй болно.

2. Ажилд хэрэглэгдэх барилгын материалд тавигдах шаардлага:

Ашиглаж буй материалууд нь чанарын хувьд олон улсын хэмжээнд болон Монгол улсад хүлээн зөвшөөрөгдсөн чанар стандартыг бүрэн хангасан байх. /БНБД стандартад нийцсэн байна./

- Барилгын материалууд нь хүний эрүүл мэндэд хор нөлөөгүй, аюулгүй, эрүүл ахуйн шаардлагыг дээд зэргээр хангасан шинэ, ашиглагдаагүй, сүүлийн үеийн дэвшилтэт технологи, хандлагыг бүрэн хангасан байх бөгөөд тохирлын гэрчилгээ, сертификат, паспорт, лабораторын шинжилгээний дүнг материал татахад хамт ирүүлсэн байна.
- Мөн Монгол улсын Засгийн газрын 2015 оны “Жагсаалт батлах тухай” 336 дугаар тогтоолоор батлагдсан Дотоодын үйлдвэрээс худалдан авах чанар, стандартын шаардлага хангасан барааны жагсаалтад орсон материалыг заавал авч ашиглах бөгөөд тайланг гүйцэтгэлд тусгаж ирүүлнэ.
- Орон нутгаас элс хайрга зэрэг барилгын материал авч хэрэглэх тохиолдолд заавал лабораторид шинжлүүлж, орцын нормыг тодорхойлуулсан байна.
- *Шаардлага хангасан тухай шинжилгээний бичиггүй түүхий эд, материалыг барилга угсралтын ажилд хэрэглүүлэхгүй болно.*

3. Барилга угсралтын ажлын зохион байгуулалт, хөдөлмөр хамгааллын ажилд тавигдах шаардлага

Барилгын үйлдвэрлэлд дагаж мөрдөх хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны дүрэм БНБД 12-03-04, Барилгын үйлдвэрлэлийн хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны дүрэм БНБД 12-

04-06, Барилга угсралтын ажилд мөрдөх хөдөлмөр хамгааллын үлгэрчилсэн заавар БД 12-101-05, Барилгын үйлдвэрлэлийн зохион байгуулалт БНБД 12-01-09 зэрэг дүрмийг мөрдөж ажиллах.

4. Газар шороо, буурь суурийн ажилд тавигдах шаардлага

Барилгын газар шороо ба буурь суурийн ажил БНБД 50-02-17*, өрөгт бүтээц БНБД 3.03.05-90, Угсармал бетон төмөр бетон бүтээц БНБД 3.03.02-90-ийг мөрдөж ажиллана.

Улаан шугамыг газар дээр нь тавих ажлыг тусгай эрх бүхий аж ахуй нэгж, байгууллагаар гүйцэтгүүлж, актыг бүрдүүлнэ.

Буурь хөрсийг механизмаар ухахдаа суурь суух түвшин хүртэл 20-30см дутуу үлдээж үлдсэн хэсгийг төслийн гүн хүртэл гараар ухаж, тэгшлэнэ. Бэлтгэл бетон, суурийн арматурчлалт, хэв хашмал, цутгалт ажилбар бүрийг зураг төслийн дагуу захиалагч болон зохиогчийн хяналтын дор гүйцэтгэнэ.

5. Төмөр бетон ба бетон бүтээцийн ажилд тавигдах шаардлага:

Бетон ба төмөр бетон бүтээц үндсэн дүрэм БНБД 52-01-10 Цутгамал бетон төмөр бетон бүтээц БНБД 52-02-05 Угсармал бетон төмөр бетон бүтээц БНБД 52-03-05 –г тус тус мөрдөж норм дүрмийн дагуу төмөр бетон баганан суурь, дам нуруу, төмөр бетон хучилт, бусад бетон хийцлэлийн ажлыг гүйцэтгэнэ. Ажлын зурагт заагдсаны дагуу арматурчлал, хэв хашмалыг угсарсаны дараа цутгах зөвшөөрөл захиалагч болон зохиогчоос авч суурь, дам нуруу, хучилтын ажлыг бетон анги В20 буюу М250 бетоноор цутгана. Барилгын ажилд хэрэглэгдэх хайрга дайрга элсийг итгэмжлэгдсэн лаборатороор орцын нормыг тодорхойлуулсны дараа бетон цутгалтын ажлыг эхлүүлнэ. Хоногийн дундаж температур 5°C доош орсон үед цутгалтыг ажлыг гүйцэтгэхийг хориглоно. Цутгамал төмөр бетон суурийн ажлыг өвлийн улиралд хийх, хөлдөөж бэхжүүлэхийг хатуу хориглоно.

Суурийн бетоныг цутгалтын аргаар гүйцэтгэхдээ хэв хашмалын ажлыг MNS3173:2002 шаардлагыг, хэвэнд хэрэглэгдэх мод төмөр хуванцар ба бусад төрлийн дагалдах тоноглол нь MNS0914:86, MNS4237:94, MNS 2630:89, MNS 2332:89, MNS 3219:82-ийн шаардлагыг хангаж байх ёстой. Цутгалтанд хэрэглэх хайрга, дайргыг MNS0390:1998, бетон зуурмаг нь MNS1185:1998 техникийн шаардлагыг хангасан байна.

Суурь – Цутгамал төмөр бетон баганан

Суурийн бетон бэлтгэл – 10см зузаан В7.5 ангийн бетон байна.

Суурийн хажуугаар овойлт үүсэхгүй хөрсөөр эргүүлэн булна. Нягтруулалтыг шалгуулах

Суурийн хөрстэй харьцах хэсэгт хар тосон түрхлэгийг 2 удаа чанартай хийх.

Бетон арчилгааг MNS стандарт дүрмийн дагуу хийх. Бетоны дээж шоог цутгамал бетоной адил нөхцөлд бэхжүүлэх

6. Модон бүтээцийн ажилд тавигдах шаардлага:

Хаалга модон бүтээцийн ажлыг Модон бүтээц БНБД54-02-05-ын дагуу гүйцэтгэнэ MNS CAN/CGSB-11.3:2011 Шахмал хавтан ба модон эдлэхүүн, материалд Монгол улсын стандарт MNS-ийг мөрдөнө. Шахмал хавтан, Зүсмэл материал 18 хувиас ихгүй чийгтэй байх ба паспорт сертификатай байна.

7. Хаалга цонхны ажилд тавигдах шаардлага

Барилгын цонхонд хэрэглэж буй үндсэн болон туслах материал нь /MNS 5802:2007 Барилгын цонх техникийн шаардлага, MNS 5830:2007 Барилгын хуванцар цонх хаалга Техникийн шаардлага, MNS 5874:2008 хэлбэржүүлсэн цувимал эдлэхүүн, MNS 6266:2011 Барилгын хана, цонхны уулзварын угсралтын заадлын дагуу техникийн шаардлага зэргийг

хангасан цонх хаалгыг угсрах, материал нь гарал үүслийн гэрчилгээ, чанарын сертификат, үйлдвэрийн албан ёсны хаяг, шошготой байх бөгөөд 70мм-с дээш өргөнтэй, 5-с дээш тасалгаатай байна. Металл зүрхэвчний ханын зузаан нь 1.2 мм-ээс багагүй зэврэлтээс хамгаалсан цайрдсан, өнгөлгөөтэй тухайн цувималдаа зориулсан хийц хэмжээтэй төмөр байна. Төмрийг хуванцар бэлдэцийн дотор талд залгаагүй жигд хийсэн байна. MNS5830:2007 стандартын 5.7-д заасан шаардлагыг хангасан байна.

8. Хана хамар ханын өрөгт бүтээцийн ажилд тавигдах шаардлага

Өрөгт ба арматурласан өрөгт бүтээц БНБД 2.03.02-09, Өрөгт бүтээц БНБД 51-02-05-ийг мөрдлөг болгох ба өргийн зуурмагт MNS 2916-80-ын шаардлага хангасан элс хэрэглэнэ. MNS 5772:2011 Барилгын дотор хана- Угсармал хавтан Техникийн шаардлага Керамик тоосго гулдмай MNS 0138:2010 Барилгын гадна ханын шавардлагатай дулаан тусгаарлалтын ажлын техникийн дүрэм БД 12-103-07 дүрмийг мөрдөж ажиллана.

Барилгын хана- 20 см хийт бетон /блок/, 10 см хөөсөн полистрол дулаалга, 12см-ын тоосго

Дулаалгын хөөсөн полистрол хавтан нь MNS EN 13163:2011 "Барилгын дулаан тусгаарлах материал. Хөөсөн полистирол (EPS) бүтээгдэхүүн. Техникийн шаардлага"-ыг хангасан байна.

Хананы дулаалгын хөөсөнцөр – 35 марк, 25.1-35 кг/м³ нягттай, 100мм-н зузаантай байна.

9. Дээврийн ажилд тавигдах шаардлага

"Дээврийн ажил" БНБД 31-07-05, "Дээврийн хучлага" БНБД 31-02-03, "Дээвэр болон ус тусгаарлалтын хуйлмал материал Техникийн шаардлага" MNS 6303:2011, "Барилгын дулаан тусгаарлах материал. Хөөсөн полистирол (EPS) бүтээгдэхүүн. Техникийн шаардлага" MNS EN 13163:2011 зэргийг тус тус мөрдөж ажиллах.

Дээврийн ажлыг дулааны улиралд чанарын маш өндөр түвшинд хийж гүйцэтгэх шаардлагатай. Зурагт үзүүлсний дагуу ханын уулзваруудыг бороо цасны ус нэвтрэхгүйгээр, халуун битум буюу мастик "изол"-оор нүх сүвийг сайтар битүүлж наана.

Дээврийн дулаалгын ажил нь MNS4929:2005 техникийн шаарлагыг хангасан байна. Дээврийн ажлыг зураг төсөвт тусгасны дагуу гүйцэтгэнэ.

Дээврийн дулаалгын хөөсөнцөр – 50 марк, 35.1-50 кг/м³ нягттай, 200мм-н зузаантай байна.

10. Заслын ажилд тавигдах шаардлага

Заслын ажил БНБД31-10-05, MNS5925:2008 Барилгын дотор ханын гипсэн гулдмай Техникийн шаардлага, MNS 5525:2005 Барилгын заслын ажилд хэрэглэх өнгөлгөөний замаска, Барилгын ажилд хэрэглэх цийдэм будаг Техникийн шаардлага турших арга MNS 5252:2003, MNS 4584:2003 Тосон будаг техникийн шаардлага ба турших зэрэг норм, стандартын дагуу ажлыг гүйцэтгэх ба заслын ажлыг нэмэх температуртай орчинд хийнэ.

✓ Гадна агаарын температур +8 хэмээс багагүй, өрөөний температур +10 хэмээс багагүй үед заслалын ажлыг гүйцэтгэнэ.

✓ Дотор засварын ажилд БНБД3.04.02.88-г мөрдөнө. Заслалын ажилд хэрэглэх материалууд нь MNS 5252:2003, MN S4584:98, MNS 4581:2003 техникийн шаардлагыг хангасан байна.

✓ Цонхны амалгааны засварын ажил БНБД3.04.02-88-г мөрдөнө.

11. Шалны ажилд тавигдах шаардлага

Шалны ажилд БНБД 3.04.04-90, БНБД 81-11-06 мөрдлөг болгоно.

Шал, довжооны дор хийх шороог овойлт, суулт үүсэхгүй хуурай хайрган хөрсөөр 1 үелэн нягтруулж бетон шал хийж уур ус тусгаарлалт, хөөсөнцөр дулаалга, цементэн тэгшилгээ хийж шалны керамик хавтанцар ба чулуун хавтан нааж өгнө. /Хөрсний нягтруулалтыг заавал захиалагчид шалгуулах/

Инженерийн шугам сүлжээ явж байгаа хэсгүүдэд засвар үйлчилгээ хийхэд саадгүй байх нөхцлөөр шалыг хийж өгнө. Мөн шалны бүтээцийн зузаан зураг төсөлд заасантай тохирч байх ёстой. Шалны вааран хавтанцарыг өнгө үзэмжтэй, хальтардаггүй чанартайг сонгон хэрэглэнэ.

Шалны дулаалгын хөөсөнцөр – 50 марк, 35.1-50 кг/м³ нягттай, 200мм-н зузаантай байна.

Жич: Барилгын хөгжлийн төвийн 2018 оны 06 дугаар сарын 22-ний 1/1121 дугаар албан бичгээр улс, орон нутгийн төсөв, гадаадын зээл тусламжийн хөрөнгөөр хийгдэж буй барилга байгууламжийн спорт залны шалыг Шал-БНБД31-12-08-ны 1.1, 2.5, 2.6 заалтууд, СП 31-112-2004 физкультурно-спортивгые залы. Чась 2-ийн 8.2.6-ын хүрээнд зориулалтын модон шалаар гүйцэтгүүлнэ үү. Бетон дэвсгэр бүхий шал дээр резин будаг, резин материал ашигласнаар хүний эрүүл мэндэд хор нөлөө үзүүлж, бэртэл гэмтлийн тоо огцом нэмэгдсэн тухай спортын чиглэлийн байгууллагуудаас албан бичгээр мэдээлэл ирүүлээд байгаа тухай ирүүлсэн. Иймд тус сургуулийн спорт залны шал нь зураг төсөлд резин будгаар тусгагдсан тул өөрчлөн модон шал хийх шаардлагатай

12. Халаалт, агаар сэлгэлтийн ажилд тавигдах шаардлага:

Барилгад хэрэглэгдэх уур амьсгал геофизикийн үзүүлэлт БНБД 23-01-09, Халаалт агаар сэлгэлт ба кондиционер БНБД 41-01-11, Барилгын дулаан хамгаалалт БНБД 23-02-09, Олон нийт иргэний барилга БНБД 31-03-03, Халаалт, агаар сэлгэлт ба кондиционер БНБД 41-01-11, Халаалтын системийн металл, полимер хоолой төлөвлөх ба угсрах дүрэм зэргийг тус тус мөрдөж ажиллана.

Барилгын халаах хэрэгсэл нь ган радиатор байна. Халаах хэрэгслийг хананд хөдөлгөөнгүйгээр бэхлэх шаардлагатай. Шугам хоолойд хийх хаалт, хоолой бусад тоноглолыг зурагт заагдсан эсвэл түүнтэй дүйцэхүйц чанартай материал сонгон хэрэглэх ба хийж гүйцэтгэсний дараа усаар шахаж шалгах шаардлагатай. Барилгын халаалтын системийн засвар үйлчилгээг хийхэд тохиромжтой байдлаар гүйцэтгэнэ.

Салхивчийн системийг стандартын шаардлага хангасан гөлмөн төмрөөр өнгө үзэмжтэй хийх ба зураг төсөлд заасны дагуу чанартай хийж гүйцэтгэнэ.

Дээвэрт ил гарах агааржуулалтын шахт, яндан хоолой, бохирын хоолой зэргийг цан цохихоос хамгаалж дулаалгын материал ашиглаж дулаалж өгөх шаардлагатай.

13. Дотор цэвэр, бохир усны ажилд тавигдах шаардлага

- Дотор цэвэр, бохир, усны системийн угсралтын ажлыг гүйцэтгэхдээ БНБД 3.05.01-88, Барилгын доторх усан хангамж ариутгах татуурга БНБД 40-05-98/2005 тус тус мөрдлөг болгоно.

- Цэвэр хүйтэн усны шугамыг цайрдсан ган болон бохир усыг хуванцар хоолойгоор дамжуулан бохир усны төвлөрсөн шугамд холбоно. Цэвэр усны шугам сүлжээний бөмбөлгөн хаалтууд болон холбох хэрэгсэл тоноглол зэргийг сайн чанарын материалаар хийж гүйцэтгэх ба ил явж байгаа цэвэр бохир усны шугам хоолойн бэхэлгээг сайн хийх шаардлагатай.

14. Гадна дулаан, цэвэр, бохир усны ажилд тавигдах шаардлага

Ус хангамж, гадна сүлжээ ба байгууламж БНБД 40-02-16, Ариутгах атуурга, гадна сүлжээ ба байгууламж БНБД 40-01-14, Гадна дулаан, цэвэр бохир усны шугамын холболтыг гүйцэтгэхдээ БНБД 3.05.04-90. Ус хангамж бохир ус татуургын гадна шугам сүлжээ түүний барилга байгууламж БНБД 3.02.04-90-г тус тус мөрдлөг болгоно. Гадна дулааны ажлыг техникийн нөхцөлд заасныг чанд мөрдөж ажиллана. Шугамын угсралтыг зурагт заасны дагуу

холбогдох төв шугам одоо байгаа уурын зуухнаас холбогдоно. Одоо байгаа ТЗУ-0.63-н хатуу түлшний зуухыг 1.5МВт-ийн зуухаар сольж өргөтгөнө.

Яндан хоолойг угсралтын үед гадна хог бохирдлоос цэвэрлэж, зэврэлтээс хамгаалах түрхлэг хийн зориулалтын пенополиуретан материалаар дулаалж өгнө. Ус дамжуулах шугамын доод цэгт юүлэх, дээд цэгт хийн хаалтыг угсрах ба гулсах болон үл хөдлөх тулгуурыг зурагт заасны дагуу байрлуулна.

Дулаан цэвэр усны шугамын угсралтын ажил дууссаны дараа даралттай усаар шахаж шалган туршилт тохируулга хийх шаардлагатай.

Бохир усны шугамыг хуванцар яндан хоолойгоор зурагт заасан налуутайгаар угсрана. Шугам хоолойг хөлдөхөөс хамгаалж дулаалж өгөх шаардлагатай. Шугамын трассын дагуу хөрсийг сайтар нягтруулж өгнө.

15. Дотор, гадна цахилгаан хангамжийн ажилд тавигдах шаардлага

Цахилгаан техникийн ажил БНБД 3.05.06-90, Цахилгаан байгууламжийн дүрэм БД 43-101-03, Орон сууц олон нийтийн барилгын цахилгаан төхөөрөмжийг төсөллөх ба угсрах БД 43-102-07 зэрэг дүрэм болон бусад холбогдох норм дүрэм стандартыг мөрдөж ажиллах.

Цахилгааны ажлыг зураг төсөвт тусгагдсан кабелиар барилгын норм дүрэм стандартын дагуу чанартай хийх шаардлагатай. Унтраалга, разетка нь ус чийгнээс хамгаалагдсан, зурагт заагдсан эсвэл түүнтэй дүйцэхүйц чанартай материал байна. Газардуулгыг зураг төслийн дагуу хийж гүйцэтгэх.

Гадна цахилгааны ажлыг зураг төсөл, холбогдох техникийн нөхцлийн дагуу барилгын норм дүрэм стандартын шаардлага хангасан зурагт заагдсан эсвэл түүнтэй дүйцэхүйц чанартай материал сонгон авч хийж гүйцэтгэнэ.

Цахилгаан хангамжийн хаалттай дэд өртөөний ажилд зураг төслийн дагуу холбогдох норм дүрмийг мөрдөж ажиллана.

6кВ ба 0.4 кВ-ын хүчдэлд трансформаторын дэд өртөөний газардуулгын байгууламж нь ерөнхий нэг байх ба эсэргүүцлийн хэмжээ нь 4 Ом-оос ихгүй байна.

16. Гадна шат, довжоо тохижилтын ажилд тавигдах шаардлага

Авто зогсоол БНБД 21-05-10, Барилгын орчны тохижилт БНБД 3.01.06-90 Явган замын ажлыг "Явган зам, талбайн хавтан техникийн шаардлага" MNS 4699:2016, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн орох гарах гарцыг MNS 5682:2006 -г тус тус мөрдөж ажиллах. Мөн шат, довжоо, зам талбайн цутгалтын ажлыг гүйцэтгэхдээ БНБД 3.03.02-90-г баримтална.

Гадна шат, довжооны ажлыг зурагт заасны дагуу барилгын гадна хаалганд газрын өндөржилт, байршилд тохируулан хийнэ.

Мөн хөгжлийн бэрхшээлтэй, тахир дутуу иргэдэд зориулсан тэргэнцрийн налуу замыг арзгар хальтирах гулсахаас сэргийлсэн материалаар гүйцэтгэх ба барилгын гадна орцын өмнө, барилгын дотор талд БД31-101-04-д заасны дагуу хийж өгнө.

17. Гадна, дотор холбоо дохиоллын ажилд тавигдах шаардлага

Барилга байгууламжийн гал унтраах төхөөрөмж, дохиоллын хэрэгсэл БНБД 21-04-05, Барилгын дотор холбоо, дохиоллын сувагчлал ба кабелийн угсралт хийх MNS5471:2005 болон бусад холбогдох норм дүрмийг мөрдөж ажиллана.

Дотор холбоо дохиоллын ажлыг зураг төслийн дагуу БНБД, стандартын шаардлага хангасан зураг төсөлд тусгагдсан чанартай материалаар хийж гүйцэтгэнэ. Галын дохиоллын станцыг үл тасалдах тэжээлийн блокоос тэжээгдэнэ.

АЖЛЫН ТОО ХЭМЖЭЭ

Тендерийн үнийн саналд зураг төсвийн үнэ 10,000,000 төгрөгийг нэмж тусган ирүүлнэ.

№	Гүйцэтгэх ажлын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ
Газрын ажил			
1	Барилга барих талбайг 140 морины хүчтэй бульдозроор тэгшлэх	м ²	4050
2	Эксковатороор шавар хөрсийг ухаж шороог автомосвалд ачиж зөөж хаях	м ³	6346
3	Гараар засч ухах	м ³	478
4	Сууринд тохирох шороог автомосвалд ачиж авч ирэх	м ³	4337
5	Суурийн хажуугаар хөрсийг мехнизмаар түрж булах	м ³	1935
6	Суурийн хажуугаар шороо гараар чигжиж эргүүлж булах	м ³	263
7	Шалан доор шороо хийх	м ³	2139
8	Шалан доорх шороог хийн транбовкоор нягтруулах	м ³	2139
Суурийн ажил			
1	Бетон бэлтгэл хийх М150	м ³	79.6
2	Баганын төмөр бетон суурь цутгах БМ250	м ³	240.5
3	Төмөр бетон шугаман суурь цутгах М-250	м ³	53.2
4	300 мм зузаантай сувгийн бетон хана цутгах М-250	м ³	461.5
5	Суурийн босоо ус тусгаарлагч хар тосоор хийх	м ²	460.42
5	Зоорийн гадна хана хөөсөнцөр хавтангаар дулаалах /6-10см/	м ²	391
6	Хөөсөнцөрийн гадна талаар 12 см-ийн тоосгон хана өрөх	м ²	393
Цутгамал төмөр бетон рамын ажил			
1	Төмөр бетон багана цутгах м250	м3	271.2
2	Багана арматурчлах /нормоос илүү зөрүү нь/	тн	11.177
3	Төмөр бетон багана цутгах м250/дамнуруу суух	м3	25
4	Төмөр бетон дамнуруу цутгах м250	м3	445.3
5	Дамнуруу арматурчлах /нормоос илүү зөрүү нь/	тн	21.836
Хана, хамар ханын ажил			
1	200 мм-ийн өргөнтэй блокон гадна хана өрөх	м2	1865
2	½-ын өргөн ердийн тоосгон хамар хана арматурлаж өрөх	м2	2298.8
3	Гипсэн хавтангаар тусгаарлагч хана угсрах	м2	204
4	200 мм-ийн өргөнтэй блокон дотор хана өрөх	м2	673.3
5	Я-12.12.14 угсармал ялуу угсрах	ш	73
6	Я-15.12.14 угсармал ялуу угсрах	ш	49
7	Я-18.12.14 угсармал ялуу угсрах	ш	46
8	Шилэн гулдмайгаар хана өрөх	м2	52
9	Гипсэн хавтан хана угсрах	м2	204
10	Модон дам нуруу угсрах	м3	8.05
11	Цэвэр банзан бамбай хамар хана хийх	м2	54
Хаалга, цонхны ажил			
1	3м ² хүртэл талбайтай модон хаалга угсрах	м2	260.12
2	Хаалганы зай завсрыг баллонтой шүршдэг хөөсөөр чигжих	м2	260.12
3	Хаалганд цоож суулгах	ш	118
4	2м2 хүртэл талбайтай вакум цонх угсрах	м2	23.76
5	2м2-аас дээш талбайтай вакум цонх угсрах	м2	524.63
6	Шилэн хана ШХ-1,2 угсрах	м2	30.62
7	Цонхонд өнгөлсөн гантгиг тавиур суулгах	м2	67.236
8	Цонхны зай завсрыг баллонтой шүршдэг чигжиж дулаалах	м2	599.43
Хучилтын ажил			
1	Төмөр бетон хучилт цутгах м-250	м3	542.7
2	Төмөр бетон хучилт арматурчлах /нормоос илүү зөрүү нь/	тн	12.5
3	Хучилтын хүчитгэл арматурчлал	тн	1.752
4	Төмөр дам нуруу угсрах	тн	14.6058

5	Холбоос татуурга угсрах	тн	1.8
6	Төмөр дам нурууг 2 удаа будах	тн	16.4058
7	Дам нуруу, парapedийн бэхэлгээ төмөр суулгах	тн	0.6895
8	Төмөр бетон парaped цутгах м-250	м3	91
Дээврийн ажил			
1	Дээврийн 15 мм зузаан цементэн тэгшилгээ хийх	м2	1217.46
2	Дээврийн 1 үе наамал уур тусгаарлагч хийх	м2	1217.46
3	Хөөсөнцөр дулаалгын дээр тор тавих	м2	1217.46
4	Хөөсөнцөр хавтангаар дээврийн дулаалга хийх /50 маркийн 31,5-50кг/м3 б=200 мм/	м2	1217.46
5	Дээврийн 1 үе толь	м2	1217.46
6	Дээврийн карамзит бетон тэгшилгээг 50-150мм-ийн зузаантай хийх	м2	1217.46
7	Дээврийн ус тусгаарлагч бикрос маркийн уян резинийг 2 үе наах	м2	1217.46
8	Хөөсөнцөр дулаалгатай төмөр сендвич хавтангаар дээвэр хийх	м2	686
9	Дээвэр дээр салхивчийн тоосгон яндан өрөх	м2	58
10	Салхивчийн тоосгон яндан шавардах	м2	116
11	Барилгын гадна талын төмөр эдлэлүүд ус зайлуулах хоолойн хамт хийх	м2	2065
Шалны ажил			
1	Бетон шал цутгах БМ200	м3	200.6
2	Шал арматурчлах	тн	1.304
3	Бетон шалны дээр 20 мм зузаан цементэн тэгшилгээ хийх	м2	376.15
4	Цементэн тэгшилгээний зузааны өөрчлөгдөх 5мм тутамд нэмэх /дараагийн 30-60см-т/	м2	3385.3
5	Хөөсөнцөр материалаар шал дулаалах /50 марк,31,5 -50кг/м3/	м3	171.502
6	Чулуун хавтан дэвсэж шал хийх	м2	775.54
7	Шалны 1 үе ус тусгаарлагч хийх	м2	6940
8	20мм зузаан цементэн тэгшилгээ хийх /хулдаас, ризенин, паркетан шалны доорх/	м2	3990.75
9	Цементэн тэгшилгээний зузааны өөрчлөгдөх 5мм тутамд нэмэх	м2	5409.2
10	Цементэн зуурмаг дээр вааран хавтангаар шал хийх	м2	249.82
11	Арматуртай бетон тэгшилгээ 30мм	м2	1715.02
12	Бетон хучаасын зузааны өөрчлөгдөх 5 мм тутамд нэмэх /дараагийн 20см-т/	м2	6860.08
13	Паркетан шал хийх	м2	755.46
14	Гидрозойлоор 1 үе тусгаарлалт хийх	м2	1777.3
15	Хүйтэн түрхлэг дээр хулдаас нааж шал хийх	м2	2023.26
16	Дуу, дулаан тусгаарлагчийг эрдэс хөвөн хавтангаар хийх	м2	2836.5
17	Ус тусгаарлагчийг шингэн шилтэй цементэн зуурмагаар хийх	м2	249.82
18	Бетон шаланд ризенин будаг хийх	м2	945.85
Шатны ажил			
1	Шатны төмөр бетон гишгүүр, талбай чигжиж цутгах	м3	34.6
2	Шатны гишгүүрийг өнгөлсөн гантиг хавтангаар	м2	74.25
Барилгын дахин хэрэглэгдэхгүй хог хаягдал			
1	Барилгын хог ялгаж овоолох ба автомашинд эксковатораар ачих	м3	55.33
Дотор халаалт			
Халаалтын систем №1			
1	D=15 мм голчтой халаалтын ган яндан угсрах	м	185
2	D=20 мм голчтой халаалтын ган яндан угсрах	м	144
3	D=25 мм голчтой халаалтын ган яндан угсрах	м	58
4	D=32 мм голчтой халаалтын ган яндан угсрах	м	91

Handwritten signature or mark

5	D=50 мм голчтой халаалтын ган яндан угсрах	м	30
6	Бэлдэц бэлтгэх яндангийг голч ф-15-25 мм	м	387
7	Бэлдэц бэлтгэх яндангийг голч ф-32 мм	м	91
8	Бэлдэц бэлтгэх яндангийг голч ф-50 мм	м	30
9	Яндан хоолойн дулаалга хийх ф-15 мм	м2	0.71
10	Яндан хоолойн дулаалга хийх ф-20 мм	м2	8.8
11	Яндан хоолойн дулаалга хийх ф-25 мм	м2	9.67
12	Яндан хоолойн дулаалга хийх ф-32 мм	м2	17.8
13	Яндан хоолойн дулаалга хийх ф-50 мм	м2	7.6
14	Бөмбөлгөн хаалт голч d-15 мм байрлуулах	ш	37
15	Баланслагч хаалт голч d-15 мм байрлуулах	ш	6
16	Баланслагч хаалт голч d-20 мм байрлуулах	ш	20
17	Баланслагч хаалт голч d-25 мм байрлуулах	ш	2
18	Баланслагч хаалт голч d-32 мм байрлуулах	ш	2
19	Хийн кран тавих	ш	24
20	Ус буулгагч ф-15 мм байрлуулах	ш	6
21	Ус буулгагч ф-20 мм байрлуулах	ш	20
22	Ус буулгагч ф-25 мм байрлуулах	ш	2
23	Ус буулгагч ф-32 мм байрлуулах	ш	2
24	Шахаж шалгах яндан хоолойн d-50мм	м	508
Халаалтын систем №2			
1	D=15 мм голчтой халаалтын ган яндан угсрах	м	170
2	D=20 мм голчтой халаалтын ган яндан угсрах	м	120
3	D=25 мм голчтой халаалтын ган яндан угсрах	м	58
4	D=32 мм голчтой халаалтын ган яндан угсрах	м	91
5	D=50 мм голчтой халаалтын ган яндан угсрах	м	30
6	Бэлдэц бэлтгэх яндангийг голч ф-15-25 мм	м	348
7	Бэлдэц бэлтгэх яндангийг голч ф-32 мм	м	91
8	Бэлдэц бэлтгэх яндангийг голч ф-50 мм	м	30
9	Яндан хоолойн дулаалга хийх ф-15 мм	м2	0.71
10	Яндан хоолойн дулаалга хийх ф-20 мм	м2	7.85
11	Яндан хоолойн дулаалга хийх ф-25 мм	м2	9.67
12	Яндан хоолойн дулаалга хийх ф-32 мм	м2	17.8
13	Яндан хоолойн дулаалга хийх ф-50 мм	м2	7.6
14	Бөмбөлгөн хаалт голч d-15 мм байрлуулах	ш	33
15	Баланслагч хаалт голч d-15 мм байрлуулах	ш	6
16	Баланслагч хаалт голч d-20 мм байрлуулах	ш	18
17	Баланслагч хаалт голч d-25 мм байрлуулах	ш	2
18	Баланслагч хаалт голч d-32 мм байрлуулах	ш	2
19	Хийн кран тавих	ш	22
20	Ус буулгагч ф-15 мм байрлуулах	ш	6
21	Ус буулгагч ф-20 мм байрлуулах	ш	18
22	Ус буулгагч ф-25 мм байрлуулах	ш	2
23	Ус буулгагч ф-32 мм байрлуулах	ш	2
24	Шахаж шалгах яндан хоолойн d-50мм	м	469
Халаалтын систем №3			
1	D=15 мм голчтой халаалтын ган яндан угсрах	м	90
2	D=20 мм голчтой халаалтын ган яндан угсрах	м	93
3	D=25 мм голчтой халаалтын ган яндан угсрах	м	28
4	D=32 мм голчтой халаалтын ган яндан угсрах	м	152
5	D=50 мм голчтой халаалтын ган яндан угсрах	м	27
6	Бэлдэц бэлтгэх яндангийг голч ф-15-25 мм	м	211
7	Бэлдэц бэлтгэх яндангийг голч ф-32 мм	м	152

8	Бэлдэц бэлтгэх яндангийг голч ф-50 мм	м	27
9	Яндан хоолойн дулаалга хийх ф-15 мм	м2	12.72
10	Яндан хоолойн дулаалга хийх ф-20 мм	м2	14.6
11	Яндан хоолойн дулаалга хийх ф-25 мм	м2	4.84
12	Яндан хоолойн дулаалга хийх ф-32 мм	м2	29.6
13	Яндан хоолойн дулаалга хийх ф-50 мм	м2	6.8
14	Бөмбөлгөн хаалт голч d-15 мм байрлуулах	ш	54
15	Баланслагч хаалт голч d-15 мм байрлуулах	ш	12
16	Баланслагч хаалт голч d-20 мм байрлуулах	ш	18
17	Баланслагч хаалт голч d-32 мм байрлуулах	ш	2
18	Хийн кран тавих	ш	25
19	Ус буулгагч ф-15 мм байрлуулах	ш	12
20	Ус буулгагч ф-20 мм байрлуулах	ш	18
21	Ус буулгагч ф-32 мм байрлуулах	ш	2
22	Шахаж шалгах яндан хоолойн d=50мм	м	418
23	Хавтгайлжин радиатор korado 22-3080-5мм/ термостат винтелийн хамт/	ш	157
24	Хавтгайлжин радиатор korado 33-3080-5мм/ термостат винтелийн хамт/	ш	16
25	Хавтгайлжин радиатор korado 33-3100-5мм/ термостат винтелийн хамт/	ш	16
26	Хавтгайлжин радиатор korado 33-5080-5мм/ термостат винтелийн хамт/	ш	13
Агаар сэлгэлтийн ситем О-1			
1	Агаар сэлгэлтийн цайрдсан хоолой 400x300	м2	14
2	Агаар сэлгэлтийн цайрдсан хоолой 450x300	м2	10.5
3	Агаар сэлгэлтийн цайрдсан хоолой 500x400	м2	12.6
4	Агаар сэлгэлтийн цайрдсан хоолой 600x400	м2	26
5	Агаарын тэгш өнцөгт огтлолтой хоолойн өвдгөвч 90 градустай хийж бэлтгэх	ш	2
6	Агаарын тэгш өнцөгт огтлолтой хоолойн шилжүүлэгчийн бэлдэц хийж бэлдэх	ш	5
7	Агаар оруулах сараалж P600*400	ш	1
8	Агаар оруулах сараалж P300	ш	15
9	Агаар халаагч EOS90-50/45N=45кВт/цахилгаан/	ш	1
10	Агаарын фильтр VFK90-50	ш	1
11	Сэнс RPH90-50/45-6D. P=450Па n=930эрг/мин N=3.78кВт L=6000м3/цаг	ш	1
12	Зөөлөн холбоос DV90-50	ш	2
13	Автомат удирдлагатай жалюз LKS90-50/230	ш	1
14	Хоолойн дулаалга хийх	м2	1.4
Агаар сэлгэлтийн ситем О-2			
1	Агаар сэлгэлтийн цайрдсан хоолой 400x300	м2	14
2	Агаар сэлгэлтийн цайрдсан хоолой 450x300	м2	10.5
3	Агаар сэлгэлтийн цайрдсан хоолой 500x400	м2	16.2
4	Агаар сэлгэлтийн цайрдсан хоолой 600x400	м2	40
5	Агаарын тэгш өнцөгт огтлолтой хоолойн өвдгөвч 90 градустай хийж бэлтгэх	ш	3
6	Агаарын тэгш өнцөгт огтлолтой хоолойн шилжүүлэгчийн бэлдэц хийж бэлдэх	ш	3
7	Агаар оруулах сараалж P300	ш	15
8	Агаар халаагч EOS90-50/45N=45кВт/цахилгаан/	ш	1
9	Агаарын фильтр VFK90-50	ш	1

Handwritten signature and date

10	Сэнс RPH90-50/45-6D. P=450Па n=930эрг/мин N=3.78кВт L=6000м3/цаг	ш	1
11	Зөөлөн холбоос DV90-50	ш	2
12	Автомат удирдлагатай жалюз LKS90-50/230	ш	1
13	Хоолойн дулаалга хийх	м2	1.4
Агаар сэлгэлтийн систем С-1			
1	Агаар сэлгэлтийн цайрдсан хоолой 400x300	м2	19.6
2	Агаар сэлгэлтийн цайрдсан хоолой 450x300	м2	12
3	Агаар сэлгэлтийн цайрдсан хоолой 500x400	м2	10.8
4	Агаар сэлгэлтийн цайрдсан хоолой 600x400	м2	16
5	Агаарын тэгш өнцөгт огтлолтой хоолойн өвдгөвч 90 градустай хийж бэлтгэх	ш	1
6	Агаарын тэгш өнцөгт огтлолтой хоолойн шилжүүлэгчийн бэлдэц хийж бэлдэх	ш	5
7	Агаар гаргах сараалж P1100*400	ш	1
8	Агаар оруулах сараалж P300	ш	15
9	ТОХИРУУЛАХ КЛАПАН 300*200	ш	1
10	Сэнс RPH90-50/45-6D. P=450Па n=930эрг/мин N=3.78кВт L=6000м3/цаг	ш	1
11	Зөөлөн холбоос DV90-50	ш	2
12	Хоолойн дулаалга хийх	м2	1.4
Агаар сэлгэлтийн систем С-2			
1	Сэнс RPH70-40/35-6D N=1,096кВт P=100Па n=920эрг/мин L=3150м3/цаг	ш	1
2	Зөөлөн холбоос DV70-40	ш	2
3	Агаар сэлгэлтийн цайрдсан хоолой 200x200	м2	5.6
4	Агаар сэлгэлтийн цайрдсан хоолой 400x400	м2	32
